

UCS 1202B:2022

ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ГАДНА ОРЧИН




Худалдаа үйлчилгээний газрын гадна сурталчилгааны
байгууламжид тавих ерөнхий шаардлага

ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ГАДНА ОРЧИН

Худалдаа үйлчилгээний газрын гадна сурталчилгааны
байгууламжид тавих ерөнхий шаардлага

*Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 22-р тогтоолоор батлав.*



ГАРЧИГ

1. Хамрах хүрээ	4
2. Норматив эшлэл.....	4
3. Нэр томъёоны тодорхойлолт	4
4. Гадна зар сурталчилгааны байгууламжийн төрөл, ангилал	5
5. Зар сурталчилгаанд тавих ерөнхий шаардлага	6
6. Гадна сурталчилгааны байгууламжид тавих шаардлага	8
7. Гадна хаяг, сурталчилгааны байгууламж байрлуулах, суурилуулахад тавих шаардлага	9
8. Ашиглалтын шаардлага, засвар үйлчилгээ.....	12
9. Шалгуур үзүүлэлт	13
Ашигласан материалын жагсаалт	14

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 13.Гадна хаяг, зар сурталчилгааны байгууламж (Жишээ зураг).....	7
Зураг 14. Гадна сурталчилгааны байгууламжид тавих шаардлага (Жишээ зураг)	8
Зураг 15. Гадна хаягийн байгууламжид тавих шаардлага (Жишээ зураг).....	9
Зураг 16. Гадна сурталчилгаа байрлуулах (1-р зэргийн гол гудамжны жишээ зураг).....	10

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Гадна зар сурталчилгааны төрөл ангилал	6
Хүснэгт 2.Гадна зар сурталчилгааны зарчим	7
Хүснэгт 3.Сурталчилгааны байгууламжид хяналт, үнэлгээ хийх чиглэл.....	12
Хүснэгт 4.Гадна сурталчилгааны байгууламж хүлээн авах шалгуур үзүүлэлт.....	13



**НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2022 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 22

Улаанбаатар хот

┌ Худалдаа, үйлчилгээний газрын гадна ┐
орчинд хамаарах хотын стандартыг батлах
тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт; Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэг, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10¹ дүгээр зүйлийн 10^{1.1} дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй, амьдрах эрхийг хангахад чиглэсэн Худалдаа, үйлчилгээний газрын гадна орчин бүлэгт хамаарах дор дурдсан стандартуудыг хавсралтаар баталсугай. Үүнд:

1.1. UCS1201B:2022 “Худалдаа, үйлчилгээний газрын гадна орчны ерөнхий шаардлага” хотын стандарт

1.2. UCS 1202B:2022 “Худалдаа, үйлчилгээний газрын гадна сурталчилгааны байгууламжид тавих ерөнхий шаардлага” хотын стандарт

1.3. UCS1203B:2022 “Амралтын газар, жуулчны баазын гадна болон дотоод орчны тохижилт, зохион байгуулалтад тавих ерөнхий шаардлага” хотын стандарт

2. Батлагдсан хотын стандартуудыг мөрдүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д даалгасугай.

3. Энэхүү тогтоолыг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1110100316



Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 22
дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ГАДНА ОРЧИН

USC 1202B:2022 “ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ГАДНА СУРТАЛЧИЛГААНЫ БАЙГУУЛАМЖИД ТАВИХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА” ХОТЫН СТАНДАРТ

1. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү стандарт нь худалдаа, үйлчилгээний байгууллагын гадна сурталчилгааны байгууламжид тавих ерөнхий шаардлагыг тогтооно.

2. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү стандарт нь эш татсан дараах хууль, барилгын норм ба дүрэм, стандартын шаардлагыг бүрэн хангах бөгөөд өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн эх материалыг үндэслэл болгоно.

- Зар сурталчилгааны тухай хууль;
- Нийслэлийн нутаг дэвсгэрт гадна зар сурталчилгаа байрлуулахад дагаж мөрдөх журам НИТХ-ын 2017 оны 9/10 дугаар тогтоол;
- MNS 5283 : 2022 Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгө, аж ахуйн нэгж, байгууллагын хаягийн тэмдэгт тавих ерөнхий шаардлага;
- MNS 6775:2019 – Хаяг, Хаягийн бичвэрт тавих шаардлага;
- MNS 5217:2017 – Монгол кирилл үсгийн латин хөрвүүлэг;
- “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”;
- “Цахилгаан техникийн угсралтын дүрэм”.

3. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Гадна сурталчилгааны байгууламж – гэж нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд самбар гэрэл дохио, гэрэлтүүлэг болон хөдөлгөөнгүй бусад төхөөрөмжийг ашиглан хийсэн зар сурталчилгаа.

4. ГАДНА ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ БАЙГУУЛАМЖИЙН ТӨРӨЛ, АНГИЛАЛ

- 4.1. Нийтийн тээврийн зогсоол дахь байгууламж;
- 4.2. Загварт байгууламж нь бараа, бүтээгдэхүүний бодит дүрслэл, загварыг алдагдуулахгүйгээр хэрэглэгчдийн анхаарал татахуйц шийдлээр бүтээж тодорхой өгүүлэмж бүхий байгууламж;
- 4.3. Хоргот байгууламж буюу барилга байгууламжийн үзмэрийн цонхонд эсхүл салангид байрлах байгууламжийг;
- 4.4. Лед гэрлэн байгууламж буюу тусгах төхөөрөмж ашиглан газар, хана орон зайд дүрс буулгах зориулалттай байгууламжийг;
- 4.5. Нүхэн гарцын байгууламж буюу нүхэн гарцын салшгүй бүрдэл хэсэгт байрлуулсан байгууламжийг;
- 4.6. Хөдөлгөөнт байгууламж буюу бүх төрлийн хөдөлгөөнт биетийн гадаргууд байрлуулсан байгууламжийг;
- 4.7. Хаягийн байгууламж дараах төрлүүд байна. Үүнд:
 - 4.7.1. нэгдсэн хаягийн байгууламж;
 - 4.7.2. гэрэлт хайрцаг /light box/;
 - 4.7.3. эзлэхүүнт үсэг бүхий байгууламж;
 - 4.7.4. неон гэрлэн байгууламж;
 - 4.7.5. лед гэрлэн;
 - 4.7.6. хулдаасан, даавуун хэвлэл бүхий;
 - 4.7.7. туг далбаат.
- 4.8. Гадна зар сурталчилгааны байгууламжийн төрөл ангиллын загварыг Хүснэгт 1-т үзүүлэв.

Хүснэгт 1. Гадна зар сурталчилгааны төрөл ангилал

Тулгуурт байгууламж	Гүүрэн байгууламж	Нийтийн тээврийн зогсоол дахь байгууламж	Хөдөлгөөнт байгууламж
 <p>Зураг 1. (Жишээ зураг)</p>	 <p>Зураг 2. (Жишээ зураг)</p>	 <p>Зураг 3. (Жишээ зураг)</p>	 <p>Зураг 4. (Жишээ зураг)</p>
Нүхэн гарцын байгууламж	Дээврийн байгууламж	Барилгын ханан дахь байгууламж	Барилгын хашаа хаалт дээрх байгууламж
 <p>Зураг 5. (Жишээ зураг)</p>	 <p>Зураг 6. (Жишээ зураг)</p>	 <p>Зураг 7. (Жишээ зураг)</p>	 <p>Зураг 8. (Жишээ зураг)</p>
Загварт байгууламж	Түр байгууламж	Лед гэрлэн байгууламж	Хоргот байгууламж
 <p>Зураг 9. (Жишээ зураг)</p>	 <p>Зураг 10. (Жишээ зураг)</p>	 <p>Зураг 11. (Жишээ зураг)</p>	 <p>Зураг 12. (Жишээ зураг)</p>

5. ЗАР СУРТАЛЧИЛГААНД ТАВИХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

5.1. Гадна хаяг, мэдээллийн байгууламж нь орчин үеийн технологийн шийдлийг ашигласан байх бөгөөд засвар, үйлчилгээг тогтмол хийж, бүрэн бүтэн байдлыг хангуулна.

5.2. Гадна зар сурталчилгааны байршил, байрлуулах хугацаа нь хот тохижилт, инженерийн хангамжийн байгууллагуудын бүтээн байгуулалт, засвар, үйлчилгээний ажлын график, төлөвлөгөөтэй нягт уялдсан байна.



Зураг 13. Гадна хаяг, зар сурталчилгааны байгууламж (Жишээ зураг)

5.3. Нийслэлийн нутаг дэвсгэрт, гадна зар сурталчилгаа байрлуулахтай холбоотой үүсэх үйл ажиллагаанд баримтлах зарчмыг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 2. Гадна зар сурталчилгааны зарчим


Хууль тогтоомж	Монгол Улсын Үндсэн хууль, Зар сурталчилгааны тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Газрын тухай хууль болон бусад хууль тогтоомж
Дүрэм журам	Нийслэлийн нутаг дэвсгэрт гадна зар сурталчилгаа байрлуулахад дагаж мөрдөх журам /НИТХ-ын 2017 оны 9/10 тогтоол/
Аюулгүй байдал	Орчны аюулгүй байдлыг хангах
Нэг орчин – Нэг хэв маяг	Хотын гудамж, барилга байгууламжийн нэгдсэн өнгө төрхтэй уялдуулах
Инновац	Орчин үеийн шинэ техник, технологи нэвтрүүлэхийг эрмэлзэх

5.4. Гадна зар сурталчилгааны байгууламжийг “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”, “Цахилгаан техникийн угсралтын дүрэм”, Барилгын норм, нормативын дагуу байрлуулж, ашиглалтад оруулна.

5.5. Барилга байгууламжийн хана, дээвэрт байрлуулсан сурталчилгааны байгууламж нь тухайн барилгын аюулгүй, бүрэн бүтэн байдал, өнгө үзэмжийг алдагдуулахгүй байна.

6. ГАДНА СУРТАЛЧИЛГААНЫ БАЙГУУЛАМЖИД ТАВИХ ШААРДЛАГА


- 6.1. Гадна зар сурталчилгааны байгууламж дээрх сурталчилгааны бичвэр нь Засгийн газрын 2013 оны 37 дугаар тогтоолд заасны дагуу монгол /кирилл/ үсгээр алдаагүй бичигдсэн байх ба зохиогчийн эрхээр баталгаажсан бараа, бүтээгдэхүүний лого дээрх бичвэрт энэ нь хамаарахгүй.
- 6.2. Зар сурталчилгаа нь үнэн, хэрэглэгчдэд хүртээмжтэй байж, агуулга, хэлбэр, түүнийг түгээж байгаа арга хэрэгслээс үл хамааран зар сурталчилгаа гэж ойлгогдохоор байна.



Зураг 14. Гадна сурталчилгааны байгууламжид тавих шаардлага (Жишээ зураг)

- 6.3. Замын хөдөлгөөний болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хяналтын камер, хөдөлгөөн зохицуулах гэрэл дохио, авто замын тэмдгийн үзэгдэх орчныг халхлахгүй байна.
- 6.4. Гадна зар сурталчилгаа нь авто зам болон явган замын зорчих хөдөлгөөнд саад учруулахгүй байх бөгөөд замын байгууламжаас хэвтээ проекцоор 1м зайтай байна.
- 6.5. Бусдын эзэмшлийн газар, объектыг ашиглан нийтийн эзэмшлийн гудамж зам, талбайд гадна сурталчилгаа түгээх бол эзэмшигчтэй албан ёсоор зөвшилцсөн байна. Гадна сурталчилгаанд тавих ерөнхий шаардлагыг Зураг 2-т үзүүлэв.
- 6.6. Гадна хаягийн байгууламжийг нийтийн эзэмшлийн гудамж, талбайд байрлуулах нөхцөлд дараах хэм хэмжээг баримтална: Үүнд:
- автомашин болон явган хүний хөдөлгөөнд саад учруулахгүй, үзэгдэх орчныг хязгаарлахгүй байх;
 - замын байгууламжаас 1 метрээс багагүй зайд байрлах;

- авто зам, инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн ажил хийгдэхээр төлөвлөж байгаа газарт байрлуулахгүй байх.



Зураг 15. Гадна хаягийн байгууламжид тавих шаардлага (Жишээ зураг)

7. ГАДНА ХАЯГ, СУРТАЛЧИЛГААНЫ БАЙГУУЛАМЖ БАЙРЛУУЛАХ, СУУРИЛУУЛАХАД ТАВИХ ШААРДЛАГА

- 7.1. Гадна зар сурталчилгаа нь тухай барилга байгууламжийн архитектур дизайнтай уялдсан байх бөгөөд иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангасан байна.
- 7.2. Гадна зар сурталчилгаа нь замын хөдөлгөөний болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хяналтын камер, хөдөлгөөн зохицуулах дохио, тэмдэг, тэмдэглэлтэй төстэй байх, тэдгээрийг халхлах, далдлах болон бусад хэлбэрээр хөдөлгөөнд саад учруулахыг хориглоно.
- 7.3. Гадна зар сурталчилгааг байрлуулах, суурилуулахдаа орчны аюулгүй байдлыг хангах бөгөөд бат бөх, чанарын стандарт, шаардлага хангасан байна.



Зураг 16. Гадна сурталчилгаа байрлуулах (1-р зэргийн гол гудамжны жишээ зураг)

- 7.4. Барилгын хана, дээвэр дээр сурталчилгааны байгууламж байрлуулахдаа дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй. Үүнд:
- барилгын үндсэн хийц, бүтээцийг алдагдуулахгүй;
 - цонхны үзэгдэх орчныг халхлаагүй;
 - орон сууц, оффисын цонхоор хурц гэрэл тусгахгүй байх;
 - цахилгаан холболтын аюулгүй байдлыг хангах, нормыг мөрдөх;
 - замын хөдөлгөөний зохицуулалтын тэмдэгтэмдэглэгээтэй андуурагдахгүй;
 - тэлэгчтэй боолт ашиглах.
- 7.5. Зар сурталчилгааны байгууламжийг нийтийн эзэмшлийн талбайд байрлуулах болон суурилуулахдаа дараах зүйлсийг анхаарна. Үүнд:
- суурийн гүнийг самбарын өндөртэй харьцуулан тооцоолох;
 - зам талбайн бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүй, нөхөн сэргээх;
 - замын хөдөлгөөний зохицуулалтын тэмдэгтэмдэглэгээтэй андуурагдахгүй;
 - бетон анкерын боолтоор бэхлэх.
- 7.6. Гадна зар сурталчилгааны тулгуур шонгийн суурийн ажлыг гүйцэтгэхэд БНБД 3.02.01-90-г баримтална.
- 7.7. Суурийг цутгалтын аргаар гүйцэтгэхэд БНБД 52-02-05-ыг мөрдлөг болгоно.
- 7.8. Элсийг стандартын шаардлагад тохирсон, бетон зуурмаг MNS1185:1985 техникийн шаардлагыг хангасан байна.
- 7.9. Гадна зар сурталчилгааны түр байгууламж буюу улирлын болон түр хугацаагаар ажиллах нээлттэй үзэсгэлэн зах, сүүдрэвч бүхий үйлчилгээ, арга хэмжээний үед гадаад орчноос ажиглагдахаар байрлуулсан байгууламжийг байрлуулах болон суурилуулахдаа дараах зарчмыг баримталбал зохино. Үүнд:

- автомашин болон явган зорчигчийн хөдөлгөөний аюулгүй үзэгдэх орчныг халхлахгүй байх;
- том хэмжээтэй хулдаасан хэвлэл бол салхины хүчийг бууруулах нүх гаргах;
- хөнгөн жин бүхий сурталчилгааны байгууламж байрлуулж, суурилуулахдаа бэхэлгээ, хүндрүүлэгч ашиглах.

7.10. Гадна зар сурталчилгааг доор дурдсан газруудад байрлуулахыг хориглоно. Үүнд:

- соёлын өвд бүртгэсэн хөшөө дурсгал, түүх, соёлын дурсгалт газар;
- музей;
- дархан цаазат газар;
- архитектурын өвөрмөц хийц бүхий барилга байгууламж;
- сүм, хийдийн барилга, түүний байнгын хашаа, хайс;
- төрийн байгууллага болон нутгийн захиргааны байгууллагын барилга байгууламж, түүний эзэмшлийн газарт.

8. АШИГЛАЛТЫН ШААРДЛАГА, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ

- 8.1. Бохирдол, элэгдэл, эвдрэлээс шалтгаалан иргэдэд гэмтэл бэртэл учруулахаас сэргийлж гадна сурталчилгааны байгууламжид 14 хоног тутамд хяналт, үнэлгээ, засвар, үйлчилгээ хийнэ.
- 8.2. Гадна зар сурталчилгааны байгууламжийг зүй бусаар ашиглах, хохирол учруулах, сүйтгэх, устгах, гэмтээх, зүй зохисгүйгээр ашиглахыг хориглоно.
- 8.3. Гадна сурталчилгааны байгууламжид хяналт үнэлгээ хийх чиглэлийг Хүснэгт 3-т үзүүлэв.

Хүснэгт 3. Сурталчилгааны байгууламжид хяналт, үнэлгээ хийх чиглэл

	Хяналт үнэлгээ хийх чиглэл	Тийм	Үгүй
1	Бохирдолтой эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Сурталчилгааны самбар бүрэн бүтэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Бэхэлгээ, эд анги, элэгдсэн, суларсан, гэмтсэн, мултарсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Эвдэн сүйтгэх үйл ажиллагаанд өртсөн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Гэрэлтүүлэг бүрэн бүтэн ажиллаж байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6	Цахилгаан холболтын аюулгүй, хэвийн байдал	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
7	Гадна өнгө, будаг хэвийн	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Тайлбар: Сурталчилгааны байгууламжийн ашиглалтын нөхцөл байдал нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол **“Тийм”** хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол **“Үгүй”** хэсгийг тэмдэглэнэ.

9. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Гадна зар сурталчилгааны байгууламж энэ стандартад заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянан, шалгаж хүлээн авна.

Хүснэгт 4.Гадна сурталчилгааны байгууламж хүлээн авах шалгуур үзүүлэлт

	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Гадна зар сурталчилгааны байгууламж дээрх сурталчилгааны бичвэр нь Засгийн газрын 2013 оны 37 дугаар тогтоолд заасны дагуу монгол / кирилл/ үсгээр алдаагүй бичигдсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Зар, сурталчилгааны байгууламжийн суурилуулалт, бэхэлгээ шаардлага хангаж байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Барилга байгууламжийн хана, дээвэрт байрлуулсан сурталчилгааны байгууламж нь тухайн барилгын аюулгүй, бүрэн бүтэн байдал, өнгө үзэмжийг алдагдуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Гадна зар, сурталчилгааны байгууламж нь замын хөдөлгөөний болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хяналтын камер, хөдөлгөөн зохицуулах гэрэл дохио, авто замын тэмдгийн үзэгдэх орчныг халхалсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Барилга байгууламжийн хана, дээвэрт байрлуулсан сурталчилгааны байгууламж нь тухайн барилгын аюулгүй, бүрэн бүтэн байдал, өнгө үзэмжийг алдагдуулаагүй эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Тайлбар: Худалдаа үйлчилгээний газрын гадна зар сурталчилгаа нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол **“Тийм”** хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол **“Үгүй”** хэсгийг тэмдэглэнэ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- Зар сурталчилгааны тухай хууль
- Хаягжуулалтын тухай хууль
- MNS 5283:2014 – Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдэглэгээнд тавих ерөнхий шаардлага
- Нийслэлийн нутаг дэвсгэрт гадна зар сурталчилгаа байрлуулахад дагаж мөрдөх журам – Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 04 дугаар сарын 27-ны өдрийн 9/10 дугаар тогтоол
- Гадна зар сурталчилгааны байгууламжид тавих тусгай шаардлага батлах тухай - Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 2013 оны 10 дугаар сарын 08 өдрийн А/170 дугаар тушаал

ТЭМДЭГЛЭЛ

Blank writing area with horizontal dotted lines.



Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗАР



Хан-Уул дүүрэг, 23-р хороо, 17100, Наадамчдын зам
1200, Нутгийн захиргааны цогцолбор байр.



70118030, 70118040



www.standard.ub.gov.mn



Хотын стандарт, хяналтын газар